


БАТЛАВ

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

2020 оны 03 дугаар сарын 24-ны өдөр

## 142 ДУГААР СУРГУУЛЬД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ /БЗД, 10 ДУГААР ХОРОО/

### ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт: 142 ДУГААР СУРГУУЛЬД ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ /БЗД, 10  
ДУГААР ХОРОО/

Төслийн дугаар: УБЗАА ДХХ 2020/022

Улаанбаатар хот  
2020он

Сангийн сайдын 2013 оны 05  
дугаар сарын 31-ний өдрийн 125  
дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## **МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

### **ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА  
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

*2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.*  
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар  
2013 он

## ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА**

**Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

*Нийслэлийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба* нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **142 дугаар сургуульд тоног төхөөрөмж худалдан авах /БЗД, 10 дугаар хороо/**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 09 цаг 00 минут** -аас өмнө цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 дүгээр сарын 10** -ны өдрийн **09 цаг 10 минут**-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9, Нийслэлийн засаг захиргааны II байр, Хангарьд ордон.  
6-н давхарт 610 тоот**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. <b>ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ</b>	
<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Сүүлийн <b>2</b> жилийн санхүүгийн аудитлагдсан тайланг /2018 он, 2019 он/ дүгнэлтийг хамт ирүүлэх</p> <p>Сүүлийн <b>2</b> жилийн /2018 он, 2019 он/ хугацаанд ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээний хуулбар, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл/</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 90%-аас доошгүй байх</li> <li>2. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, бараа нийлүүлэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ.</li> <li>3. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>4. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>5. Татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>6. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг нотолсон мэдэгдэл ирүүлнэ. Хэрэв зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</li> <li>7. Баталгаат хугацаанд ашиглагч талаас шалтгаалаагүй гарсан эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээг хийх тухай мэдэгдэл ирүүлнэ.</li> </ol> <p>ТШӨХ-д заасан аль нэг баримт бичиг дутуу ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минут</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) – ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9, Нийслэлийн засаг захиргааны II байр, Хангарьд ордон.</b></p> <p>Давхар болон ерөөний дугаар: <b>6-н давхарт 610 тоот</b></p> <p>Аймаг, хот: Улаанбаатар хот</p> <p>Улс: Монгол Улс</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p><b>2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 09 цаг 10 минут</b></p>

<p><b>ТӨӨЗ 2.3</b></p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. /нотариатаар баталгаажуулсан байх/</li> <li>2. Үндсэн үйл ажиллагааны чиглэл-Гадаад, дотоод худалдаа эрхэлдэг байх</li> <li>3. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлэх</li> <li>4. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх ба Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг татаж шалгана. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдээгдэл ирүүлнэ.</li> <li>5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлнэ</li> <li>6. Харилцагч банкны тодорхойлолт ирүүлнэ. /өр төлбөргүй байх/</li> <li>7. Үнийн саналыг баталгаажуулж ирүүлнэ /маягтын дагуу/</li> <li>8. Барааны үнийн болон нийлүүлэх хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. /маягтын дагуу/</li> <li>9. Нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт болон гаалийн баталгааг монгол хэлээр баталгаат орчуулгын газраар орчуулж гэрэл зургийн хамт хавсаргаж ирүүлнэ.</li> <li>10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дахь заалтыг хангаж буй эсэг мэдээгдэл ирүүлэх</li> <li>11. Дээрх тодорхойлолтуудыг /албан бичиг/ тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна. Өмнө авсан албан бичиг байвал ирүүлээгүйд тооцож тендерээс татгалзах үндэслэл болно.</li> </ol>
<p><b>ТӨӨЗ 6.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b></p>



## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Баянзүрх дүүргийн 32 дугаар цэцэрлэгт нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн үзүүлэлтийг хангасан байна. Мөн баталгаат хугацаа нь 12 сар байна.
2. **Стандарт:** Барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.
3. **Баглаа, боодол:** Бараа нь хайрцаг сав, баглаа боодолтой, шинэ байна.
4. **Бараа хүргэх газар:** Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо 142 дугаар сургууль
5. **Шалгалт, туршилт:** Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор захиалагч болон ашиглагч байгууллага нь барааг шалгаж туршилтаар ажиллуулж үзэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг тендерт оролцогч эх хувиар тендерт баталгаажуулан ирүүлнэ.

### Барааны тодорхойлолт

1	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн тодорхойлолт
1	Даралтат хөгжим	ширхэг	1	<p>PSR-S670 Yamaha эсвэл түүнтэй дүйх. Дунд сургуулиудад өргөн ашиглагддаг бараа байвал давуу тал болно. Дараах 3 төрлийн бараа дагалдах шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Даралтат хөгжимний адаптер 1 ширхэг: /PA-300C/</li> <li>2. Хөгжмийн суурь 1 ширхэг : JS-500C</li> <li>3. Холбогч кабель 1 ширхэг: MJ-MJ /3M/</li> </ol> <p>Даралтат хөгжимний үзүүлэлт:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 416 voices (including Mega Voices), 34 Drum/SFX kits and 480 XG Voices</li> <li>2. Authentic sampled sounds including superb acoustic superb acoustic and electric pianos, and electronic sounds perfect for today's dance music</li> <li>3. New Intelligent Arpeggio function with Instant access to a library of arpeggiated synth phrases and patterns</li> <li>4. 230 Styles including a brand new DJ category</li> <li>5. Two live controllers for instant control over effects and other functions, including filter, arpeggio and track mute</li> <li>6. Expansion Memory-add new Voices, drum kits and styles for extra versatility and enhanced performance</li> <li>7. Authentic Voices and Styles from around the world</li> </ol>
2	Өсгөгч /дипузер/	Ширхэг	2	<ol style="list-style-type: none"> <li>1. 1000BT хүчин чадалтай</li> <li>2. Микшерь пультруу орох оролттой</li> <li>3. Стандартын чанар хангасан.</li> </ol>
3	Зайны микрофон	ком	6	Утасгүй микрофон, чанарын шаардлага хангасан, антенний хамт

4	Утастай микрофон	Ширхэг	3	Стандарт оролттой.
5	Чанга яригч болон микшерийн холбогч кабель иж бүрдэл	метр	40	2x25=50метртэй
6	Микшерийн пульт	ширхэг	1	8 зам дээр зэрэг ажиллах хүчин чадалтай. Стандартын шаардлагад нийцсэн.
7	Цахилгаан хөгжмийн иж бүрдэл	Иж бүрдэл	1	Иж бүрдэлд дараах хөгжмийн зэмсэгийг тооцно. Үүнд: 1. Бөмбөрийн иж бүрдэл /Бөмбөрийн цан зузаан Yamaha бөмбөртэй дүйх/ 2. Цахилгаан басс гитар /Yamaha басс гитартай дүйх/ 3. Цахилгаан соло гитар /Yamaha соло гитартай дүйх/ 4. Цахилгаан ритм гитар / Yamaha ритм гитартай дүйх/
8	Ятга	Ширхэг	6	Их гарын ятга. 16 утастай.
9	Ёочин	ширхэг	1	Их гарын ёочин. Дагалдах хэрэгсэл: 1. Хөл 2. Цохиур

6. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Даралтат хөгжим	<p>PSR-S670 Yamaha <b>эсвэл түүнтэй дүйх.</b> Дунд сургуулиудад өргөн ашиглагддаг бараа байвал давуу тал болно. Дараах 3 төрлийн бараа дагалдах шаардлагатай. Үүнд:</p> <p><b>4. Даралтат хөгжимний адаптер 1 ширхэг: /PA-300C/</b></p> <p><b>5. Хөгжимийн суурь 1 ширхэг : JS-500C</b></p> <p><b>6. Холбогч кабель 1 ширхэг: MJ-MJ /3M/</b></p> <p>Даралтат хөгжимний үзүүлэлт:</p> <p>8. 416 voices (including Mega Voices), 34 Drum/SFX kits and 480 XG Voices</p> <p>9. Authentic sampled sounds including superb acoustic superb acoustic and electric pianos, and electronic sounds perfect for today's dance music</p> <p>10. New Intelligent Arpeggio function with Instant access to a library of arpeggiated synth phrases and patterns</p> <p>11. 230 Styles including a brand new DJ category</p> <p>12. Two live controllers for instant control over effects and other functions, including filter, arpeggio and track mute</p> <p>13. Expansion Memory-add new Voices, drum kits and styles for extra versatility and enhanced performance</p> <p>Authentic Voices and Styles from around the world</p>	1	ширхэг	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	

Өсгөгч /дипузер/	4. 1000BT хүчин чадалтай 5. Микшерь пультруу орох оролттой Стандартын чанар хангасан.	2	Ширхэг	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Зайны микрофон	Утасгүй микрофон, чанарын шаардлага хангасан, антенний хамт	6	ком	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Утастай микрофон	Стандарт оролттой.	3	Ширхэг	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Чанга яригч болон микшерийн холбогч кабель иж бүрдэл	2x25=50метрэй	40	метр	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Микшерийн пульт	8 зам дээр зэрэг ажиллах хүчин чадалтай. Стандартын шаардлагад нийцсэн.	1	ширхэг	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Цахилгаан хөгжмийн иж бүрдэл	Иж бүрдэлд дараах хөгжмийн зэмсэгийг тооцно. Үүнд: 5. Бөмбөрийн иж бүрдэл /Бөмбөрийн цан зузаан Yamaha бөмбөртэй дүйх/ 6. Цахилгаан басс гитар /Yamaha басс гитартай дүйх/ 7. Цахилгаан соло гитар /Yamaha соло гитартай дүйх/ Цахилгаан ритм гитар / Yamaha ритм гитартай дүйх/	1	Иж бүрдэл	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Ятга	Их гарын ятга. 16 утастай.	6	Ширхэг	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Ёочин	Их гарын ёочин. Дагалдах хэрэгсэл: 3. Хөл Цохиур	1	ширхэг	БЗД-ийн 10-р хороо, 142 дугаар сургууль	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан моо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**<sup>1</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.



**ЗАХИАЛАГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*